



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/688

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 2 иргэн, 1 хуулийн этгээдийн нийт 0.3392 га (3392м²) газрыг хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-д тус тус зөвшөөрсүгэй.


3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
12 дугаар сарын 28-ны өдрийн
А. 588 дүгээр захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСАЛТ

№	Эрх шилжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Халиучин овгийн Бадарч Хадбаатар (РЮ072102738)	Хиргис овгийн Бярзана Төмөр-Очир (РХ83120912)	6712017290	Гэр, орон сууцны хашааны газар	13-р баг 17-32в тоот	815	28	Аймгийн Засаг даргын 2016.05.16-ны өдрийн А/258 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 3 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	Хамар овгийн Шаравжамц Зоригтбаатар (РЮ087090538)	Хамар овгийн Шаравжамц Амгаланбаатар (РЮ000212451)	6712008101	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	6-р баг Од-2 212 тоот	1079	26	Аймгийн Засаг даргын 2013.04.10-ны өдрийн А/67 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 5 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
3	"Молордавалгаа" ХХК (РД:5419492)	"Эм Ди роял трэйдинг" ХХК (РД:6720854)	6712017383	Үйлчилгээтэй орон сууц	7-р баг Хийморь-4 457 тоот	1498	21	Аймгийн Засаг даргын 2023.11.06-ны өдрийн А/566 дугаар захирамжийн хавсралтын 4 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 3392м²

-----ООО-----